



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/268

Булган сум

Хурдан морины бүсийн уралдаан  
зохион байгуулах тов батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.9, 13.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, 2025 оны “Хүүхдийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээний тухай” 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2026 онд зохион байгуулагдах Хурдан морины бүсийн уралдааны товыг хавсралтаар баталсугай.

2. Хурдан морины бүсийн уралдааны үеэр оролцогчдын аюулгүй байдал, хэв журмыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа, Б.Эрдэнэбилэг), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (С.Оюунзаяа), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн хурдан морины бүсийн уралдааны хөтөлбөр, хуваарийн дагуу аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллахыг “Булганхангай” морин спорт уяачдын холбоонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



0326 1 004

Аймгийн Засаг даргын 2026 оны  
04 дүгээр сарын 13-ны нийгмийн өдрийн  
...А/268... дугаар захирамжийн хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
“БҮСИЙН УРАЛДААН”-НЫ ТОВ**

Д/д	Уралдааны нэр	Уралдах нас	Уралдаан зохион байгуулах газар, хугацаа	Хариуцах эзэн
1	“Цонхлон хурд-2026” аймгийн бүсийн уралдаан	<ul style="list-style-type: none"><li>• Азарга</li><li>• Их нас</li><li>• Соёолон</li><li>• Сонгомол дээд нас</li></ul>	Сэлэнгэ суманд 2026.05.01	Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газар, “Цонхлон хурд” МСУХ
2	“Бугат хурд-2026” аймгийн бүсийн хаврын уралдаан	<ul style="list-style-type: none"><li>• Хязаалан</li><li>• Шүдлэн</li><li>• Даага</li><li>• Сонгомол дунд нас</li><li>• Сонгомол бага нас</li></ul>	Бугат суманд 2026.05.02	Бугат сумын Засаг даргын тамгын газар, “Ханд вангийн хурд” МСУХ
3	“Бүрэгхангай хурд-2026” аймгийн бүсийн хаврын уралдаан	<ul style="list-style-type: none"><li>• Азарга</li><li>• Их нас</li><li>• Соёолон</li><li>• Сонгомол дээд нас</li></ul>	Бүрэгхангай суманд 2026.05.03	Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газар “Сазан Бүрэг” МСУХ
4	“Нутгийн хурд-2026” аймгийн бүсийн хаврын уралдаан	<ul style="list-style-type: none"><li>• Хязаалан</li><li>• Шүдлэн</li><li>• Даага</li><li>• Сонгомол дунд нас</li><li>• Сонгомол бага нас</li></ul>	Дашинчилэн суманд 2026.05.09	Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газар, “Нутгийн хурд” МСУХ
5	“Ачуут хурд-2026” аймгийн бүсийн хуралдаан	<ul style="list-style-type: none"><li>• Хязаалан</li><li>• Шүдлэн</li><li>• Даага</li><li>• Сонгомол дунд нас</li><li>• Сонгомол доод нас</li></ul>	Булган суманд 2026.07.... сард	Булган сумын Засаг даргын тамгын газар, “Ачуут хүлэг” МСУХ
6	“Булганхангай” МСУХ-ны 30-н жилийн ойн баяр наадам, аймгийн бүсийн уралдаан		Булган суманд 2026.07.... сард	“Булганхангай” МСУХ